АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнхэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2024/**12**-НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2024 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор **А.Пүрэвцэцэг**<br>Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ **Error! Bookmark not defined.**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ **Error! Bookmark not defined.**

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ **Error! Bookmark not defined.**

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ **Error! Bookmark not defined.**

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ **Error! Bookmark not defined.**

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ **Error! Bookmark not defined.**

3.5.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт ........ **Error! Bookmark not defined.**

3.5.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл ........ **Error! Bookmark not defined.**

4. АУДИТЫН ТАЙЛАН ........ **Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл ........ **Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал ........ **Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ **Error! Bookmark not defined.**

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.5 Төсвийн шууд захирагчийн аудитын дүнгийн талаар ........ **Error! Bookmark not defined.**

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........

5.**1** Зөвлөмж ........

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| МУЗГ | Монгол улсын засгийн газар |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХГБХХГ | Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024-03-25 № 170
танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ГАЛХҮҮ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол Цэнхэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн доорх алдаа зөрчил нь материаллаг боловч санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь өргөн тархаагүй тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд тусгагдсан 67,810.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг зээлдэгч нэг бүртэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зээлдэгчийн мэдээлэл, бүртгэл нь зөрүүтэй, тайлант оны хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 8.4, 14.4, 20.2 дахь заалтыг зөрчсөн, аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 99.06 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,099,146.60 | 925,340.50 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 686,792.10 | 477,686.20 |
| 33 | АВЛАГА | 347,443.70 | 363,966.70 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,635.70 | 63,687.70 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 21,275.00 | 20,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,960,694.70 | 3,362,408.80 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,960,694.70 | 3,362,408.80 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,703,484.70 | 3,105,198.80 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 257,210.00 | 257,210.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,059,841.30 | 4,287,749.40 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,059,841.30 | 4,287,749.40 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,059,841.30 | 4,287,749.40 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 656,363.60 | 656,363.60 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 3,135,970.50 | 3,363,878.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 267,507.20 | 267,507.20 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,059,841.30 | 4,287,749.40 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,208,680.40 | 2,192,152.40 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,071,678.10 | 705,024.20 |
| 110 | Орлогын албан татвар | 274,005.80 | 295,013.00 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 273,953.20 | 294,832.00 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 52.6 | 181 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 110,710.20 | 119,266.70 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 686,962.10 | 290,744.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 992,648.10 | 643,937.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 992,648.10 | 643,937.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,144,354.20 | 843,190.70 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,691,563.80 | 1,538,354.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,602,763.80 | 1,538,354.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,019,766.70 | 1,530,638.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 431,225.80 | 561,310.30 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,579.40 | 70,357.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 122,182.20 | 168,618.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,448.90 | 70,291.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,553.40 | 44,410.70 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,160.00 | 9,020.60 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 91,986.70 | 198,456.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 272,630.20 | 408,126.90 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,582,997.20 | 7,716.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 88,800.00 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,517,116.60 | 653,798.10 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 4,713,791.00 | 425,890.00 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,325,150.00 | 1,780,475.50 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,071,678.10 | 705,024.20 |
| 110 | Орлогын албан татвар | 274,005.80 | 295,013.00 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 273,953.20 | 294,832.00 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 52.6 | 181 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 110,710.20 | 119,266.70 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 686,962.10 | 290,744.50 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 37,132.30 | 36,256.30 |
| 1181 | Газрын төлбөр | 242,319.20 | 58,225.70 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 407,510.60 | 196,262.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 109,117.60 | 232,260.60 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 109,117.60 | 232,260.60 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,144,354.20 | 843,190.70 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,467,806.20 | 1,288,661.90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,467,806.20 | 1,288,661.90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 875,490.50 | 1,280,945.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 431,225.80 | 561,230.30 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,579.40 | 70,357.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 122,177.20 | 32,550.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 37,412.00 | 73,932.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,169.40 | 18,520.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,160.00 | 9,020.60 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 108,637.10 | 379,460.70 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,129.60 | 135,874.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,592,315.60 | 7,716.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 857,343.80 | 491,813.70 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 816,436.40 | 635,919.60 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 816,436.40 | 635,919.60 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 816,436.40 | 635,919.60 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -816,436.40 | -635,919.60 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -118,000.00 | -65,000.00 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 118,000.00 | 65,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -77,092.60 | -209,106.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 763,884.80 | 686,792.10 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

Архангай аймгийн Цэнхэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 7,340,479.90 | 7,340,479.90 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -80,098.40 | -80,098.40 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,260,381.50 | 7,260,381.50 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -3,865.80 | -3,865.80 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -3,196,674.40 | -3,196,674.40 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,059,841.30 | 4,059,841.30 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,059,841.30 | 4,059,841.30 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,059,841.30 | 4,059,841.30 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 227,908.10 | 227,908.10 |

## **2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,052,809.60 | 1,889,435.14 | 163,374.46 | 92.04 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 13,606,993.00 | 1,304,442.06 | 12,302,550.94 | 95.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 13,529,833.00 | 1,296,726.06 | 12,233,106.94 | 95.84 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 5,716,572.00 | 561,230.31 | 5,155,341.69 | 98.18 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 714,567.00 | 70,357.39 | 644,209.61 | 98.46 |
| 2102 05 | Эрүүл мэндийн даатгал | 114,331.00 | 11,257.64 | 103,073.36 | 98.47 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,703,955.00 | 168,454.44 | 1,535,500.56 | 98.86 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 648,437.00 | 62,069.35 | 586,367.65 | 95.72 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 306,299.00 | 26,369.73 | 279,929.27 | 86.09 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 90,860.00 | 9,020.60 | 81,839.40 | 99.28 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,212,608.00 | 288,496.17 | 2,924,111.83 | 89.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,136,535.00 | 110,728.06 | 1,025,806.94 | 97.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 77,160.00 | 7,716.00 | 69,444.00 | 100.0 0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 77,160.00 | 7,716.00 | 69,444.00 | 100.0 0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,221,103.00 | 519,993.08 | 5,701,109.92 | 83.59 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 700,000.00 | 65,000.00 | 635,000.00 | 92.86 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 20,528,096.00 | 1,973,084.86 | 18,555,011.14 | 96.12 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 13,962,595.00 | 1,898,295.86 | 12,064,299.14 | 135.9 6 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 6,565,501.00 | 74,789.00 | 6,490,712.00 | 11.39 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 184,966.15 | 184,966.15 | 100.0 0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 268,615.87 | 268,615.87 | 100.0 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 74 | 74 | 0.00 | 100.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 36 | 36 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 100,146.34 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 80,574.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 80,574.34 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,863.15 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 18,520.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,387.53 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,803.66 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 19,572.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 19,572.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 100,146.34 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 100,146.34 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **67,810.0** мянган төгрөгийн зөрчил[1] илэрч зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Зөвлөмж

#### *5.1.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой*

*Илрүүлэлт:* Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд тусгагдсан *67,810.0* мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг зээлдэгч нэг бүртэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зээлдэгчийн мэдээлэл, бүртгэл нь зөрүүтэй, тайлант оны хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг таслан зогсоож, хүүгийн авлагыг тооцож нягтлан бодох бүртгэлд тусгах, авлагын үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлан дахь авлагыг баталгаажуулаагүй | 1 | 67,810.0 | - | - | 1 | 67,810.0 | | | - | - | - | - |
| **Нийт дүн** | 1 | 67,810.0 | **-** | **-** | 1 | 67,810.0 | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.